



## “МОНГОЛ ХЭЛНИЙ НУТГИЙН АЯЛГУУНЫ СУДАЛГАА” ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ



Эрдэмтэн судлаач та бүхнийг ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэл шинжлэлийн салбараас зохион байгуулж буй “Монгол хэлний нутгийн аялгууны судалгаа” олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцохыг урьж байна.

### УДИРДАМЖ

Зохион байгуулагч: ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэл шинжлэлийн салбар  
Хугацаа: 2023 оны 9 сарын 15 (09.00-17.00 цаг)

Байрлал: Улаанбаатар хот

**Зорилго:** ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэл шинжлэлийн салбар 2022-2024 онд “Монгол хэлний нутгийн аялгууны судалгаа” сэдэвт суурь судалгааны төслийг санаачлан хэрэгжүүлж байна. Энэхүү төслөөр монгол хэлний нутгийн аялгууны судалгааг урагшлуулан хөгжүүлж, нутгийн аялгууны өнөөгийн бодит байдлыг судлан судалгааны шинэлэг үр дүнд хүрэх зорилготой. Төслийн ажлын төлөвлөгөөний дагуу зохион байгуулж буй энэхүү олон улсын эрдэм шинжилгээний хурлын зорилго нь монгол хэлний нутгийн аялгууг судлагч эрдэмтэн судлаачид уулзан ярилцах, эрдэм шинжилгээний илтгэлүүдээ харилцан сонсох, хэлэлцэх, бүтээл туурвилтай нь танилцаж туршлага солилцох, эрдэм шинжилгээний байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, судалгааны цаашдын чиг хандлагыг тодорхойлоход оршино.

**Хурлын сэдвийн хүрээ:**

1. Нутгийн аялгуу судлалын уламжлалт ба шинэ онол, арга зүй
2. Нутгийн аялгуу судлалын шинжилгээний ангийн ололт амжилт, туршлага
3. Монгол хэлний аялгуунууд, аман аялгуунуудын авиа зүй, хэл зүй, үгийн сангийн судалгаа
4. Монгол хэлний нутгийн аялгууны хэрэглээний өнөөгийн байдал
5. Монгол хэлний нутгийн аялгуунуудын гарал угсаа, түүхэн замнал, өнөөгийн тархац
6. Нутгийн аялгуу ба газар нутаг, ёс заншил, соёлын өвийн холбоо харилцаа

**Хурлын албан ёсны хэл:** монгол, англи, орос

**Илтгэлд тавих шаардлага:**

- Шинжлэх ухааны үндэслэлтэй, эрдэм шинжилгээний тодорхой арга зүйг ашиглах
- Шинэлэг санаа дэвшүүлэх

- Санаагаа товч тодорхой гаргах
- Урьд өмнө нь хэвлэгдээгүй байх
- Өөр эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлээгүй байх
- Хэлэлцүүлэх илтгэлийн бичвэрт тавигдах шаардлагыг хангасан байна. Үүнд:
  1. ИЛТГЭЛИЙН НЭР (Том үсгээр, Times New Roman, үсгийн өндөр 12, тод хар үсгээр, мөр голлосон байх)
  2. Зохиогчийн овог, нэр (Times New Roman, үсгийн өндөр 12)
  3. Хураангуй (англи хэлээр 100-150 үгтэй, үсгийн өндөр 11, мөр хоорондын зай нь 1,15)
  4. Түлхүүр үг (6-8, монгол, англи хэлээр)
  5. Илтгэлийн бүрэн эх нь 5-10 нүүр байх бөгөөд мөр хоорондын зай нь 1,15
  6. Илтгэлийн ном зүйд ном, өгүүллийн нэр, хэвлэлийн мэдээллийг стандарт шаардлагын дагуу ном, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл зэргээр ялган бичнэ. Эшлэл, зүүлтэд тэмдэглээгүй бүтээлийг ном зүйд оруулахгүй.

Илтгэлийн нэр, хураангуйг хүлээн авах: 2023 оны 8 сарын 21-ний 17.00 цаг хүртэл [borolzoid@mas.ac.mn](mailto:borolzoid@mas.ac.mn) хаягаар хүлээн авна.

Илтгэлийн бүрэн эхийг хүлээн авах: 2023 оны 9 сарын 1-ний 17.00 цаг хүртэл [borolzoid@mas.ac.mn](mailto:borolzoid@mas.ac.mn) хаягаар хүлээн авна.

Зардал: Замын зардал болон зочид буудлын зардлаа илтгэгч өөрөө хариуцна.

Хуралд оролцох эрдэмтэн, судлаачдын илтгэлийг цахимаар бүртгэн, 2023 оны 8 сарын 22-ны өдөр судлаачдад мэдэгдэнэ.

Олон улсын эрдэм шинжилгээний хурлын бүртгэл:

Оролцогчийн овог нэр	
Байгууллагын нэр	
Эрдмийн зэрэг, цол	
Илтгэлийн нэр	
Илтгэлийн товчлол (монгол хэлээр 100-150 үг)	
Түлхүүр үг	
Цахим хаяг	
Илтгэлийг WORD болон PDF хэлбэрийн хамтаар илгээх	
Холбогдох утас	
Шуудангийн хаяг	

Хуралд оролцогч бүр бөглөнө.

Холбоо барих газар, утас:

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Баянзүрх дүүрэг, Жуковын гудамж, ШУА-ийн хүрээлэнгүүдийн нэгдсэн нэгдүгээр байр 54 А. Мэйл хаяг: [borolzoid@mas.ac.mn](mailto:borolzoid@mas.ac.mn), Утас: 976-11-450480, 99018026, 95242984

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН,  
ХЭЛ ШИНЖЛЭЛИЙН САЛБАР

2023.07.26